

Монголын материал судлал гагнуурын нийгэмлэгийн 2014 онд хийсэн ажлын тайлан

2015 оны 01 дугаар сар 05

Нэг. Монголын материал судлал гагнуурын нийгэмлэгээс тайлангийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар

1. ММСГН-ээс 2014 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласан.
2. Монголын металл судлал гагнуурын, нийгэмлэгийн үндсэн зорилт, үйл ажиллагаа болон нийгэмлэгээс цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар байгууллага аж ахуйн нэгж, хувь хүмүүст сурталчилан танилцуулах ажлыг байнга зохион байгуулж ажиллалаа. БНХАУ-ын Бээжин хотод 2014 оны 6 дугаар сард зохион байгуулагдсан олон улсын гагнуурчдын ур чадварын ARC Cup-2014 цомын тэмцээнд оролцож багаараа 2-р байранд орсон Монголын гагнуурчдыг хэвлэл мэдээлэл, цахим шуудангаар сурталчилах ажлыг зохион байгууллаа. Мөн нийгэмлэгийн www.mmsws.mn вебсайтыг байнга ажиллуулж байна.
3. Тус нийгэмлэгт хандаж, ажил төрлийн холбоо тогтоох, гагнуурын ИТА-ыг сургалтад хамруулах, гагнуурчдыг аттестатчилалд оруулах, гагнуур, метал судлалын чиглэлээр зөвлөгөө авах, гагнуурын ажлын чанар шалгуулах гэсэн хүсэл эрмэлзэлтэй хүмүүстэй биечлэн уулзаж, аль болох дэм тус болох чиглэлээр ажиллаж байна.
4. Эрдэс баялаг эрчим хүчний сайдын 2010 оны 01 сарын 25-ны өдрийн 21 тоот тушаалаар батлагдсан “Гагнуурчид болон гагнуурын инженер технкийн ажилтныг мэргэшүүлж эрх олгох дүрэм”-ийн дагуу Оюу толгой ХХК, Зэт Эм И ХХК, Энержи Интернейшнл ХХК, Эм Пи Ай ХХК, Мега Стийл Фабрикаторс ХХК, Эм Си Эс Интернейшнл ХХК, Рэд Паф ХХК, Эрин Интернейшнл ХХК, Хасумегаватт ХХК, Спирт Бал Бурам ХХК, Зэт Эм Стийл ХХК зэрэг үйлдвэр, аж ахуй нэгж, байгууллагын 193 мэргэшсэн гагнуурчин болон Монгол Германы МСҮТ-ийн сургалтад хамарсан 116 гагнуурчдаас мэргэжлийн шалгалт авч гэрчилгээ олгосон болно.
5. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол сургалт” төслийн шугамаар Монгол Германы МСҮТ дээр зохион байгуулсан МСҮТ-үүдийн хагас автомат гагнуурын онолын болон дадлагын багш нарын мэргэшил дээшлүүлэх сургалтын хүрээнд нийт гагнуурын 12 багшаас гагнуурчны мэргэжлийн шалгалт авч гэрчилгээ олгосон. Энэ ажил нь МСҮТ-ийн гагнуурын багш нарын онол, дадлагын ур чадварыг дээшлүүлэх ажилд ихээхэн ач холбогдолтой болсон.

медаль, МЭЗ ХХК-ий гагнуурчин Б. Баттулга цахилгаан гагнуурын төрөлд 3-р байр, хүрэл медал тус тус хүртсэн болно.

9. Японы Гагнуурын техникийн нийгэмлэг /Хэлтсийн эрхлэгч Шойчи Номура/-тэй хамтран Монголд Гагнуурын инженер техникийн ажилтнуудын мэргэшлийн сургалт зохион байгуулах асуудлаар хэлэлцэж, тодорхой төлөвлөгөө гаргасан бөгөөд энэ асуудлаар Японы эдийн засаг, худалдаа, үйлдвэрийн яамны сайдад хандаад байна
10. Герман Монголын олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгт хандан гагнуурчдын сургалтын онолын хичээл заах, онолын хичээлийн хөтөлбөрийг боловсронгуй болгох, гагнуурын тодорхой түвшний инженер техникийн ажилтануудыг бэлтгэх, аттестатчилах, гагнуурчдаас шалгалт авах чиглэлээр ММСГН, түүний гишүүн байгууллагуудын хүрээнд ажиллах гагнуурын ажил үйлчилгээний хөгжлийн зөвлөх мэргэжилтэнийг ажиллуулах талаар албан ёсны хүсэлт тавьж шийдвэрлүүлэх шатандаа явж байна.
11. Монгол улсын Хөдөлмөрийн Яамтай хамтран “МОНГОЛ УР ЧАДВАР – 2014” тэмцээний хүрээнд МСҮТ-тэд гагнуурын мэргэжлээр суралцагчдын дунд гагнуурын төрлөөр улсын аварга шалгаруулах 2 үе шаттай тэмцээнийг тус нийгэмлэгээс зохион байгуулж явууллаа. Тэмцээнийг зохион байгуулж явуулахтай холбогдсон ур чадвар олон улсын тэмцээний танилцуулга, даалгавар, журам, үнэлгээний материалуудыг боловсруулж гаргалаа. Тэмцээнд тэргүүн байр эзэлсэн гагнуурчдыг 2015 онд Бразил улсад зохион байгуулагдах “ДЭЛХИЙН УР ЧАДВАР-2015” тэмцээнд оролцуулах болзолтой байсан учир тэмцээнийг олон улсын жишгийн дагуу модул 1 даалгаврыг гүйцэтгүүлж явуулсан. 2014 оны 4 сард ГММСҮТ дээр зохион байгуулсан эхний шатны тэмцээнд хот, орон нутгийн 33 МСҮТ-ийн суралцагч цахилгаан гагнуурын төрлөөр оролцсон. Энэ тэмцээнд эхний 5 байрт орсон гагнуурчдын дунд 2-р шатны тэмцээнийг цахилгаан болон хагас автомат гагнуурын төрлөөр 2014 оны 5 сард зохион байгуулсан бөгөөд тэмцээний 1-р байрыг Герман Монголын МСҮТ-ийн М. Доржсүрэн, 2-р байрыг Техник технологийн дээд сургуулийн Л. Ганцоож, 3-р байрыг Дорноговь МСҮТ-ийн Э. Пүрэвдорж нар эзэлж цом, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнагдсан болно. Тэмцээнд эхний 1, 2-р байр эзэлсэн суралцагч гагнуурчид олон улсын тэмцээнд өрсөлдөж оролцохоор бэлтгэлээ базааж байна.
12. Азийн гагнуурын холбоо (АГХ)-ноос тус холбооны гишүүн улсуудын хүрээнд Гагнуурчдыг аттестатчилах ерөнхий тогтолцоо буй болгох талаар эрчимтэй ажиллаж байна. Энэ чиглэлээр АГХ-ны ажлын хэсгүүд 3 дүрэм, 23 үйл ажиллагааны журам боловсруулан АГХ-ны удирдах зөвлөлөөр батлаж гаргаад байна. Одоогоор энэхүү ГАЕТ-г хэрэгжүүлэх үйл ажиллагаа явагдаж эхлээд байна. Манай ММСГН-ийн хувьд түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. Тус нийгэмлэгээс дээр дурьдсан дүрэм журмуудыг англиас монгол болгон орчуулах томоохон ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ирэх оны эхний улиралд багтаан дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна

хүсэл эрмэлзэлтэй хүмүүстэй биечлэн уулзаж, аль болох дэм тус болох чиглэлээр ажиллаж байна.

15. ММСГН-ийн ажлын 2013 оны тайланг Улсын бүртгэлийн газарт хугацаанд нь өгсөн.
16. ММСГН өөрийн санхүүгийн тайлан, татварын тайлан, нийгмийн даатгалын тайланг улирал, сар бүрээр гаргаж тооцоогоо хийж байна. Татварын тайланг цахим хэлбэрээр тоон гарын үсгээр өгч байна.
17. Нийгэмлэгийн тэргүүн А. Тлейхан, УИХ-ын гишүүн, СБД 3-р хороо, 5-р хороолол, 17-р байр, 8 тоот, гүйцэтгэх захирал Г. Дорж БЗД 26-р хороо, Баянмонгол хороолол 406-51 тоот, ерөнхий зохицуулагч Ц. Шүрэнцэцэг СХД 32-р хороо Москва хороолол 1-12 тоот, Д. Нямсүрэн БГД 15-р хороо, 3-р хороолол 23а -34 тоот, удирдах зөвлөлийн гишүүн Ж. Түмэн- Аюуш ХУД 11-р хороо 2-р хэсэг, Лагшири зайсан виллаж 5-р байр 5 тоот , Б. Зулбаяр ЧД 5-р хороо, 6-р хороолол 9-54 тоот, С. Батсайхан БГД 12-р хороо, 4-р хороолол 20-144 тоот , Ж. Төмөрхуяг БГД 1-р хороо Богд-Ар 2-р хороолол 11а байр 15 тоот Д. Эрдэнэ-Очир БЗД 12-р хороо, Дүнжингарав хороолол 107-8 тоот, Ариунсан Эрдэнэтийн УБҮ ЗМҮ, Ц. Энхтогтох БГД 1-р хороо, 06-р байр 50 тоот.


Хоёр. Нийгэмлэгийн ажилд оршиж буй дутагдал доголдол.

1. Үйлдвэрлэл, аж ахуйн зарим салбарын хүрээнд гагнуурын ажлын стандарт, шаардлагыг мөрдүүлэх ажил хийгдэхгүй байна. Энэ нь салбар, аж ахуйн нэгж, байгууллага, компаний удирдлага нь гагнуурын ажил үйлчилгээний мөн чанар, түүний стандарт, шаардлагын талаар ойлголт муутай, олон улсын жишгээс хол, гагнуурын ажлын чанар нь зөвхөн үнэмлэхтэй, үнэмлэхгүй гагнуурчнаас л хамаарах юм шиг өрөөсгөл ойлголтоос салж чадаагүйтэй холбоотой. Олон улсын хэмжээнд гагнуурчдыг аттестатчилах нийтлэг тогтолцоотой болчихоод байхад манай улсын хувьд үйлдвэрлэл аж ахуйн зарим салбарын хүрээнд нэгдсэн ойлголтод хүрч чадахгүй байсаар байгаад ММСГН дүгнэлт хийж ажиллах ёстой бөгөөд энэ талаар хангалтгүй ажиллаж байна.
2. АГХ-ны гишүүн улсын хувиар АГХ-ны гагнуурчдыг мэргэшүүлж эрх олгох шинэ тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хүрээнд гагнуурын инженер техникийн ажилтан, гагнуурын багш нарын мэдлэг, ур чадвар шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.
3. Гагнуурчдын аттестатчилал зохион байгуулж, шалгалт авах эрх бүхий ажилтаныг сургаж бэлтгэх, тэднийг батлагаажуулж эрх олгох ажил хийгдэхгүй байна
4. Тус нийгэмлэгийн дотоод ажлын хувьд нийгэмлэгийн гишүүн байгууллага, аж ахуйн нэгж, компаниас татвар, хандив цуглуулах ажил тууштай хийгдэхгүй байна
5. Материал судлалын чиглэлээр тодорхой ажил хийгдэхгүй байна.

10. Азийн гагнуурын холбооны ээлжит хурал болон тус холбооноос зохион байгуулж буй бүх төрлийн ажилд идэвхтэй оролцож байх, гагнуурын олон улсын институттай харилцаа тогтоох, улмаар гагнуурын чиглэлийн стандарт техникийн баримт бичиг боловсруулах, боловсронгуй болгох үйл ажиллагаанд оролцох
11. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад гагнуурын ажил үйлчилгээний стандарт, норм дүрмийн шаардлагыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх, гагнуурын технологи боловсруулах, гагнуурчдыг шалгаж эрх олгох, гагнаасны чанарыг шалгах, гагнуурын ажлын холбогдох баримт бичгийг бүрдүүлэх зэрэг ажилд туслах.
12. MNS ИСО 3834:2010 “Металд хайлуулах аргаар гагнуур хийх үеийн чанарын шаардлага” гэсэн цуврал стандартыг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдүүлж хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх.
13. Улаанбаатар хотод гагнуурчдын улсын аварга шалгаруулах ээлжит тэмцээнийг олон улсын жишгийн дагуу зохион байгуулах.

Тайлан бичсэн:

Гүйцэтгэх захирал



Г. Дорж